



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 106

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, тус хорооны 2025 оны 57 дугаар тогтоол, 2025 оны 101 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Жимобайл ХХК-д Улаанбаатар хот болон 21 аймаг, сум, багийн нутаг дэвсгэрт Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд 3300-3400 МГц-ийн “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийг 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрөөс 2030 оны 5 дугаар сарын 09-ний өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай.
2. Жимобайл ХХК нь тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай.
3. Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

ГИШУУД



Г.ЧИНЗОРИГ

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР